

Халх голын дайн ба Өвөр Монголд явагдсан Японы төмөр замын ажиллагаа

Б.Бүрэнсайн*



Төмөр зам нь колоничлолын хамгийн чухал хэрэгсэл юм. Дэлхийн II дайн дуусах хүртэл XX зууны эхэн хагасын Манмо Манжуур хэмээх орон нутаг өнөөгийн Хятадын зүүн хойд гурван муж, Өвөр Монголын зүүн хэсгийн Хөлөнбуйр, Жирэм (Tongliao), Улаан хад (Jiuda) болон 1942 онд устгагдсан Зостын чуулган гэсэн 4 аймгийг хамарч байсан ба япон хэлээр Манмо гэж нэрлэдэг байв. Хэрэг дээрээ II дайн дуустал энэ хэсэг газар орон Японы колони байжээ.

Манжуурт явагдсан Японы төмөр замын ажиллагаа, бодлого Мантэцүгээр дамжин хэрэгжиж иржээ. Мантэцүгийн байгуулсан төмөр замын сүлжээ нь Японы эх газрын бодлоготой нягт холбогдож ирсэн байна. Үйл ажиллагааны нь хүрээ Чанчунаас Мүгдэн, Мүгдэнгээс Далянь хүрэх төмөр зам, Даньдунаас Мүгдэн хүрэх төмөр зам болон харьяа газруудад төмөр зам барьж, хяналтандаа авах байв. Түүнээс гадна мөн нүүрсний уурхай болон бусад уурхай ашиглах зэрэг үйл ажиллагаа явуулж байв. Компаний төв нь Далянь байжээ.

1931 оны 9 дүгээр сарын 18-ны “Манжийн хэрэг явдлын” дараа. Мантэцүгийн компаний төв нь Даляниас Синьзин (Одоогийн Гирин мужийн Чанчунь хот)-д шилжиж, улмаар Мантэцү нь Манжгогийн

*Япон Улсын Шига мужийн Их сургуулийн багш, доктор (Ph D)

төмөр зам, хүнд үйлдвэрийн бааз болов. Дайн дууссанаар 1945 оны 8 дугаар сарын 27-нд Мантэцүгийн удирдлагыг Дундад иргэн улс, Зөвлөлтийн хамтарсан “Дундад Иргэн улсын Чанчуний төмөр зам” компани авчээ. Тухайн үед ажиллаж байсан инженер, ажилчид нь үлдэж, 1948 он хүртэл ажилласан байна.

Улмаар 1949 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улс болсноор Мантэцүгийн захирч байсан энэ төмөр замын сүлжээ Хятадын Зүүн Хойд бүсийн хүнд үйлдвэрийн суурь бааз болж хувирсан байна. Энэ өгүүлэлд дэлхийн II дайн дуусахаас өмнөх үеийн Манжгогийн хил доторх байсан Мантэцүгийн төмөр замын сүлжээ нь 1939 онд явагдсан Халх голын дайны байлдааны бодлогод хэрхэн холбогдогдож байсан бэ гэсэн асуудлыг хөндөж ярьмаар байна.

1. Мантэцү (Өмнөд Манжуурын төмөр зам) Манжуур, Өвөр Монголд нэвтэрсэн нь

Манж-Өвөр Монгол оронд Мантэцүгийн төмөр замын ажиллагаа ХХ зууны эхэнд Япон-Оросын дайны үеэр эхэлсэн юм.

1903 онд ашиглалтанд орсон Дорнод Хятадын төмөр зам Чичихарэгаас Манжуур хүртэлх хэсэг эхлэл болж, түүний дараа 1929 оны үед Хятадын зүүн хойт засгийн газраас Чагань хотоос Аршаан хүрэх төмөр замыг эхлэн засаж, 1931 оны Манжийн хэрэг явдлаас болж дундаа зогссон байна. Энэ бүтээн байгуулалтын ажиллагааг Японы Мантэцүгаас хариуцаж байлаа. Мөн Манжгогийн үед Дархан хошуу (Тайпинчуань)-наас Заруд Хошуу (Лубэй) хүртэлх төмөр замыг төсөвлөсөн боловч хэрэгжээгүй (ийм төмөр замын төсөл олон байсан). Түүнчлэн Харчин дунд хошуу (Юүэбаошөү)-наас Улаанхад хүртэл төмөр зам барихаар төлөвлөсөн байжээ.



*Зураг 1. Манжгогийн баруун хэсгийн Монгол нутгаар байсан
Мантэцүгийн төмөр замууд*

Манжгогийн хил доторх эдгээр төмөр замын Орос 2500 км, Англи 450 км эзэмшиж, бусад нь Орос-Манж Чин, Япон-Хятадын хамтарсан, Японы зээлд тулгуурласан. Манжгог байгуулснаас хойшхи Японы байгуулсан зэрэг олон төмөр зам байна. Иймд олон эрх ашиг зөрчилдсөн, тун будлиантай бүс нутаг юм.

1940-өөд оны үеийн Манжгогийн хил доторх Монгол нутагт байсан төмөр замын сүлжээг (зураг 2) харвал Монгол хошуудын гүн хүртэл төмөр зам барихаар төлөвлөж байсныг мэдэж болно.



Зураг 2. Манжгогийн хилд багтаж байсан Өвөр чуулганууд


Үүнд, Хөлөнбуйраас Хянган Ар муж, Хянган Зүүн муж, Жирэмийн чуулганаас Хянган Өмнөд муж, Зуу удын чуулганаас Хянганы Баруун муж, одоо дийлэнх хэсэг нь Ляонин мужид багтаж буй Зостын чуулганаас Зиньжөү муж, Рэхэ муж зэрэг өргөн хэмжээний газар орон багтаж эдгээр олон газарт хүрэх төмөр замын сүлжээ нэвтэрсэн байжээ.

2. Халх голын дайн ба төмөр зам

Японд “Номон хааны хэрэг явдал” хэмээн яригддаг Халх голын дайн 1939 оны 5 сараас 9 сарын хооронд явагдсан байна. Манмо нь Хятад-Зөвлөлт, Япон-Зөвлөлтийн хоорондын төмөр замын эрх ашгийн эдрээтэй, сүлжсэн бүс нутаг бөгөөд 1929 онд энэ бүс нутгийн төмөр замын эрх мэдлийг Жан Сюэлян Зөвлөлтөөс булаах оролдлого хийгээд амжилт олоогүй. Үүнийг “Дундад дорнодын төмөр замын хэрэг явдал” гэдэг байжээ. Түүний дараа 1932 онд Манжго улс байгуулагдаж, улмаар Мантэцү нийт Манжгогийн нутагт байсан бүх зүйлийг өөрийн эрхшээлдээ оруулж, ноёрхлоо тогтоов. 1933 онд Зөвлөлт улс Манжгог хүлээн зөвшөөрөөгүй хэдий ч Манж дахь төмөр замын эрх мэдлээ

Манжгод зараад Манжийг орхин гарах хэлэлцээр хийжээ. 1935 онд эрх мэдлээ бүрэн шилжүүлсэн боловч Оросын тал харамсжээ. Ер нь Төмөр зам бол Орос, Хятад, Японы хоорондоо эрх ашгийг булаалдах ар талын шалтгаан болж байсан. Энэ нутагт 1933 оноос япончууд Оростой эцсийн тулалдаанаа хийхээр бэлтгэж эхэлсэн байдаг. Халх голын дайн бол гэнэт үүсэн хэрэг явдал биш харин том гүний хооронд болсон төмөр замын эрх ашгийн булалдааны үр дүн гэж үзэж болох юм.


Манжгог байгуулсан цагаас эхэлсэн Манж-Монгол, Манж-Зөвлөлтийн хилийн маргаанаас шалтгаалан Япон нь Зөвлөлт-Монголтой хийх дайнаас зайлах боломжгүй гэсэн ойлголттойгоор стратегийн төмөр замыг байгуулахад бэлтгэсэн гэж үзэж болно.



Зураг 3. Манжгог байгуулагдсан эхэн үеийн байдал буюу Манжгогийн газрын байц

Зураг 3-т үзүүлсэнчлэн Хянганы нурууны дунд Аршаан хэмээх халуун рашаан гардаг газар байсан бөгөөд энд олон газрын монголчууд өргөнөөр ирж, цуглаж мэдээлэл зэргийг авдаг чухал газар байв. Солунь хүртэл төмөр зам энэ зурагт дүрслэгдсэн байна. Солуниас цааш Аршаан хүртэл их бартаатай уул байдаг. Хайлаараас энэ хүртэлх зам их бартаатай хэцүү учир япончууд заавал энд ирж, эндээс дахин


Номонхан руу явдаг байсан байна. Дээр дурдсанчлан Иргэн улсын үеийн Халуун рашаанаас Манжгогийн үеийн Вангийн сүм буюу одоогийн Хянган аймгийн Улаан хот (Хуайвэнь)-оос Солунь хүртэл төмөр зам зассан байна. Энэ үед Жан Сюэляны Засгийн газар Солунийг нээж, ашиг олох, цэргээ тэжээх зорилготой цэргийн бааз байгуулсан байна. Жан Сюэлян Японоос мөнгө зээлж, 1927 оноос эхэлж энэ газар төмөр зам барьж эхэлжээ. Улмаар Мантэцү хөрөнгө мөнгийг нь дааж үргэлжлүүлсэн байдаг. 1929 оноос Жан Сюэлян Японтой муудсанаар төмөр зам барих ажил саатаж, зогсчээ.



Зураг 4. Хуай-вэнь төмөр зам

Ийнхүү 1927 онд Зүүн 3 мужийн захиргаа Солунь бүсийг хөгжүүлэх зорилгоор Мантэцүгийн зээлд тулгуурлаж төмөр зам барьж эхэлж, 1931 онд нэгээхэн хэсгийг нь ашиглалтанд оруулсан байна. Уг төмөр замыг 1933 онд Мантэцү мэдэлдээ авчээ. 1938 онд Аршаан хүртэл нийт 337 км урт төмөр зам ашиглалтад оруулж, Номонханы хэрэг явдлын өмнөхөн амжиж дуусгажээ. Анхнаасаа Мантэцү зээл олгоод зогсоогүй хэмжилт, газар шорооны ажлыг ч хийсэн байдаг.

Зүүн Хойд нутгийн эрх баригчид Зөвлөлтийн эсрэг стратегийн зорилгоор Солунь (Хорчин баруун гарын хойт хошуу)-ний ойн аж ахуй, газар тариаланг хөгжүүлсэний дээр Япон Манжуурын хэрэг явдлыг ч үүсгэжээ.



Зураг 5. Манжгогийн нийслэл Чанчунь (Xinjing)-аас Цагаан хот хүрэх төмөр зам


Орос Монголын хил рүү чиглэсэн дайтах стратегитай төмөр замын бүтээн байгуулалт аль эрт эхэлсэн байдаг. Манжгогийн нийслэл байсан Чанчунь

(Xinjing)-аас Жирэм чуулганы Горлосын өмнө хошуугаар дайрч Цагаан хотод хүрч ирдэг. Энэ төмөр зам Цагаан хотоос хойш Вангийн сүм хүрч дахин Зураг 4-т үзүүлсэнчлэн Солунийг дайрч, Аршаан хүрдэг байна. Манж Чингийн үед Чанчунь хотоос хойшхи хэсгийн энэ төмөр замын дагуу газар орны дийлэнхи хэсэг нь Горлос өмнөд хошууны нутаг байлаа. Энэ төмөр зам нь Горлос хошууны Вангийн ордоноор дайрч байна. Онцгойлон тэмдэглүүштэй нь Горлосын өмнөд хошуу хэмээх нутаг Богд хаант Монгол улсыг байгуулахад оролцсон Зоригт баатар Тогтох тайжийн нутаг юм. Чанчунь -аас Цагаан хот хүрэх төмөр замын Балан өртөө бол яг Тогтох тайжийн төрсөн нутаг юм. XIX зууны сүүлчээс эхлэн энэ хошуунд хятадууд их хэмжээгээр түрэн орж, монголчууд нутаг усаа булаалгасан байжээ. Тогтох тайж салж Монголын тусгаар тогтнолд хүчээ өргөсөн түүхэн байдал энэ нутагт газар шороо идэгдэн булаагдаж, төмөр зам тавигдсантай салшгүй холбоотой юм.

3. Вангийн сүмээс Аршаан хүрэх төмөр зам тавьсан нь


1938 онд амжиж дуусгасан Вангийн сүм Аршааны төмөр зам (Huaiwen төмөр зам)-ыг 1939 онд болсон Халх голын дайны өмнө амжуулсан гэдгийг дээр дурдсан билээ. Доорх зураг 6-аас үзвэл.

Вангийн сүм-Аршааны төмөр замын бүтээн байгуулалтын зардал нийт Манжгогийн хил доторх төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө мөнгөний хамгийн их нь болохыг мэдэж болно. Энэ төмөр зам тавихад зарцуулсан хөрөнгө нь бусад төмөр зам тавьсан мөнгөнөөс дахин илүү байж. Монгол нутгийг нээн ашиглана гэсэн бизнес ач холбогдлоос Орос Японы дайны стратегийн ач холбогдол илүү байсан гэдэг тодорхой.



Зураг 6. Манжгогийн төмөр замын хөрөнгө оруулалт ба Вангийн сүм-Аршаан төмөр зам

Манжго байгуулагдсан 1932 оноос хойш, Япончууд бүх Манж Монголын төмөр замын эрхийг гартаа оруулж, Иргэн улсын үед хагас дутуу тавьсан төмөр замын дотроос дайны стратегийн чухал шугамуудыг хөндөн үзэж, далайцтай бүтээн байгуулалт хийсэн байна. Хянган нурууны энгэр дэх Вангийн сүмээс Хянганы орой дээр байгаа Аршаан хүртэлх уулархаг оронд төмөр зам тавих ажил бол хөрөнгө мөнгө түүнчлэн мэргэжлийн талаас маш хүнд бэрх ажил болох нь тодорхой. 1927 онд анх Жан Сюэлян төмөр зам тавих төсөвтөө Вангийн сүмээс Солунь хүртэл тавьж, Солуньд сууж байсан зүүн хойтын цэргийн зоорь газартай холбохыг эн тэссссргүүн тавьж байсан юм. Гэвч Хянган нурууны дээр байгаа Аршаан хүртэл төмөр зам тавихад яарч байсан нь тодорхой. Харин Манжго улс байгуулагдсаны дараа Японы хүчин шууд Орос Монголтай хил нийлэх болж, хилийн орчим хүртэл цэрэг дайны хүчин зүйлсийг бүрдүүлэх хэрэгтэй болсон байжээ. Зураг 6, 7-д үзүүлсэнээр Аршаан хүрэх төмөр зам барихад уул хөндийлөн нүхэн зам малтсан ба хөрөнгө мөнгөний хувьд Манжгогийн хил доторх нийт төмөр замын дотор тэргүүлсэн байгааг харж болно.




Зураг 7. Манжгогийн ил төмөр зам дэх нүхэн зам малтсан байдал ба

Вангийн сүм-Аршаан төмөр зам

Ийм их хөрөнгө оруулж 1938 онд энэ төмөр зам Аршаан хүртэл тавигдсан байна. Аршаан хот бол Монгол Манжгогийн хилийн шугам болж байсан Халх голоос арваад километрт байв. Дайны талбар болсон Номунханаас дөчөөд километр ойрхонбайдаг юм. 1939 оны 5 сараас эхэлсэн Номонханы дайнд оролцсон япон цэргүүд энэ төмөр замаар явж байсан тухай бага бус тэмдэглэл байдаг.

Төгсгөлд нь

Манж, Өвөр Монголын Зүүн хэсэгт Манж Чингийн ноёрхлын сүүлийн үе буюу XIX зууны төгсгөлд Орос, Манж Чин гүрэн, Японы эрх ашиг маш будлиантайгаар зэрэгцэж эхэлсэн байлаа. Их гүрний хооронд болсон энэ эрх ашгийн мөргөлдөөн нь төмөр зам тавих асуудал дээр маш тодорхой болжээ. Энэ үеэс эхлэн ар өвөр чуулган ялгаагүй Монгол нутаг Орос Японы эрх ашгийн мөргөлдөөний гол тавцан болж дэлхийн II дайн дуустал үргэлжилжээ. 1939 онд болсон Халх голын дайн бол үүний хамгийн хурц ширүүн тэмцэл байлаа. Монгол нутагт тавигдсан эдгээр төмөр зам нь ямар нэг утгаар их гүрний тэмцлийн үр дүн гэдгийг бид мэдэж болно. Иймд бид Өвөр Монгол, Монгол болон Хятад улсын хилийн бүс нутгийн 1950 оноос хойшхи үйл явцад ч анхаарах хэрэгтэй болов уу.



Зураг 8. Монгол нутгаар өнгөрөх Вангийн сүм-Аршааны төмөр замын дагуух монгол бичээс